



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 51

Хэрлэн сум

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн
Сан хариуцсан мэргэжилтний
сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.2, 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /56/ авсан Мөнхбатын Болортуяаг аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Үйлчилгээний тасгийн Сан хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч М.Болортуяаг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга /Н.Нямхатан/-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг аймгийн Татварын хэлтсийн даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнэжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР